



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/196

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум, орон нутгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлсэд олон жил үр бүтээлтэй хамт олноо манлайлан ажиллаж буй Мянгад сумын Засаг даргын газрын нягтлан бодогч Б.Намжилмаа, сахиул, галч Ц.Энэбиш, Эрүүл мэндийн төвийн эх баригч Б.Сэргэлэн, Ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн багш Б.Бадамцэрэн, Цэцэрлэгийн галч Ж.Энхбат, Соёлын төвийн галч Т.Лхагвасүрэн нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Б.Намжилмаа, Ц.Энэбиш, Б.Сэргэлэн, Б.Бадамцэрэн, Ж.Энхбат, Т.Лхагвасүрэн нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Мянгад сумын дээрх байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

